



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 309

Улаанбаатар хот

┌ Тушаалд өөрчлөлт оруулах тухай ┐

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны “Гадаадад төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” 276 дугаар тушаалын хавсралтын Батсайханы Үүрийнтуяатай холбогдолтой хэсгийн “Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгийн газар” гэснийг “Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам”, 2010 оны “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай” 581 дугаар тушаалын Шархүүгийн Эрдэнэбаяртай холбогдолтой хэсгийн Swimburne их сургуулийн магистрантурт худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар” гэснийг “Австралийн үндэсний их сургуулийн магистрантурт санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр 2 жилийн хугацаагаар”, 2004 оны “Гадаадад суралцуулах тухай” 297 дугаар тушаалын Оросоогийн Оюунчимэгтэй холбогдолтой хэсгийн “Калифорнийн их сургуулийн” гэснийг “Стратфордын их сургуулийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР